| 21 | МИБК /<br>метил<br>изобутил<br>карбинол/                    | Methylisobut<br>ylcarbinol        | $\text{C}_6\text{H}_{12}\text{O}$          | 99 | 24070-77-7 | ГОСТ 5100-85                    | Хурц<br>үнэртэй<br>өнгөгүй<br>шингэн | кг       | 2000       |
| 22 | Х-133<br>реагент                                            |                                   |                                            |    |            |                                 |                                      | кг       | 1000       |
| 23 | Стандарт<br>загвар<br>цайрын<br>хүдэр<br>CGL-108<br>CGL-105 | Concentrate<br>zincum             | Zn                                         | 99 |            | ГТЛ<br>(Дүйцэхүйц)              |                                      | гр<br>гр | 100<br>100 |

Дээрх жагсаалтад орсон 23 нэр төрлийн бодисоос

1. Калийн шүлт
2. Зэсийн сульфат (Зэсийн байван)
3. Цуу хүчлийн натрийн давс
4. Метиллоранж

5. Металл цайр гэсэн 5 төрлийн химийн бодис нь тус лабораторид ашиглагдаж байгаа тусгай зөвшөөрөлтэй бодисууд болно.

**Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц**

**Зам харилцаа, холбоо**

“Эрдэнэс критикал минериалс” ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” Уулын баяжуулах үйлдвэрийн “Хими лаборатори” төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн урагш 340 км хатуу хучилттай замаар холбогдсон. Бор-Өндөр сумын 1-р багийн нутаг дэвсгэрт, Бор-Өндөрийн уурхайчдын хотхоноос зүүн хойд зүгт 1.5 км зайд оршино.

**Эрчим хүч**

Багануур зүүн өмнөд бүсийн ЦТС-аас трансформаторын дэд станцыг тэжээнэ. Цахилгаан эрчим хүчийг 6 кВт шугамаар дамжуулах бөгөөд шугамын урт 0.5 км



## **“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ**

байна. Тооцоолсон цахилгааны бүрэн ачаалал 34.1 кВт учир ТМ-40/6 маркийн трансформатор сонгон авсан байна.

### **Дулаан хангамж**

ЭВҮТ маркийн цахилгаан халаагуураар дулааны хэрэгцээг хангана. Цахилгаан халаагуурын хүчин чадал 1 кВт байна.



Усан хангамж

Хүснэгт 8. Усны зарцуулалтын тооцоо

| № | Тодорхойлолт                   | Х.      | УСНЫ ЗАРЦУУЛАЛТ                                                |                                                   |                                                   |                                                   |                                                   | Нийт 5 жилд |
|---|--------------------------------|---------|----------------------------------------------------------------|---------------------------------------------------|---------------------------------------------------|---------------------------------------------------|---------------------------------------------------|-------------|
|   |                                | Н<br>м³ | 2022                                                           | 2023                                              | 2024                                              | 2025                                              | 2026                                              |             |
| 1 | Унд ахуйн хэрэглээн ий ус      | м³      | 0.08 <sup>1</sup> *8<br>ажилтан*35<br>0 хон=224.0              | 0.08*8<br>ажилтан*3<br>50<br>хон=224.0            | 0.08*8<br>ажилтан*3<br>50<br>хон=224.0            | 0.08*8<br>ажилтан*3<br>50<br>хон=224.0            | 0.08*8<br>ажилтан*35<br>0 хон=224.0               | 1120.0      |
| 2 | Ногоон байгууламжид ашиглах ус | м³      | 3055 ш<br>*0.04 <sup>2</sup> м³*8<br>удаа<br>услана=<br>9776.6 | 3055 ш<br>*0.04 м³*8<br>удаа<br>услана=<br>9776.6 | 3055 ш<br>*0.04 м³*8<br>удаа<br>услана=<br>9776.6 | 3055 ш<br>*0.04 м³*8<br>удаа<br>услана=<br>9776.6 | 3055 ш<br>*0.04 м³*8<br>удаа<br>услана=<br>9776.6 | 4888.0      |
| 7 | Жилийн усны хэрэгцээ           | м³      | 1201.0                                                         | 1201.0                                            | 1201.0                                            | 1201.0                                            | 1201.0                                            | 6008.0      |

**Унд ахуйн хэрэглээний ус:** Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын дагуу унд ахуйн хэрэглээний нормыг 1 хүний өдрийн 80 л-ээр тооцож гаргасан. Төсөлд нийт 8 хүн, жилд нийт 350 хоног ажиллана. Унд ахуйд

хоногт  $8 \text{ хүн} * 80.0 \text{ л/хон} = 0.64 \text{ м}^3/\text{хон}$  ус,

нэг жилд  $8 \text{ хүн} * 80.0 \text{ л/хон} = 0.64 \text{ м}^3/\text{хон} * 350 = 224.0 \text{ м}^3$

төслийн ашиглалтын 5 жилийн хугацаанд нийт 1120.0 м³ ус хэрэглэнэ.

**Ногоон байгууламжид ашиглах ус:** Ногоон байгууламжийг төслийн үйл ажиллагаатай зэрэгцэн 2022-2026 онд хийхээр төлөвлөсөн. Ногоон байгууламжид нийт 3 га талбайд модлог ургамал тарихаар төлөвлөсөн. Усалгааг ургамлын ургамалтын хугацаанд буюу 6-9 сарын хугацаанд жилд нийт 8 удаа услана.

нэг жилд (Модлог ургамал)  $3055 \text{ ш} * 8 * 40 \text{ л/хон} = 1201.0 \text{ м}^3$

төслийн нийт 5 жилийн хугацаанд ногоон байгууламжид нийт 6008.0 м³ ус хэрэглэхээр тооцсон.

**Төслийн техник, технологийн сонголтод өгөх үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж**

Баргилтын хүдрийн орд газраас цайр агуулсан хүдэр илэрээд байгаа бөгөөд одоогоор баргилт цехийн 5-р хүдрийн овоолго дээр 33.5% Fe, ойролцоогоор 7.1% Zn-ийн агуулгатай 25561 тн хүдрийг хуримтлуулаад байна. 2022 оны 1-р сард

<sup>1</sup> Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр, 0.08 м³

<sup>2</sup> Суулгац, 0.04 м³



1480-36-р блокоос 32.9% Fe, ойролцоогоор 3.5% Zn-ийн агуулгатай 5000 тн хүдэр олборлохоор байна. Иймд эхний ээлжинд нийт 33.4% Fe, ойролцоогоор 6.5% Zn-ийн агуулгатай 30561 тн төмөр цайрын хүдрийг боловсруулж 65%-ийн агуулгатай төмрийн баяжмал болон 50%-ийн агуулгатай цайрын баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөсөн. “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн баяжуулах фабрикт цайр агуулсан төмрийн хүдэр боловсруулах хагас үйлдвэрлийн туршилт хийхээр төлөвлөсөн. Туршилтын хүрээнд дараах ажлуудыг хийгдэнэ. Үүнд:

1. Хүдэр бэлтгэх, 30561 тн
2. Шаардлагатай сэлбэг, материал нийлүүлэх
3. Химийн бодис, урвалж нийлүүлэх
4. Баяжуулах фабрикт технологийн схемийн өөрчлөлт хийх
5. Химийн лабораторийн ажилтныг сургаж, дадлагажуулах, 2 ажилтан
6. Цайр тодорхойлох химийн бодис болон үйлдвэрлэлд ашиглагдах урвалжуудын эрсдэлийн үнэлгээг хийж химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийг авах нийт 23 төрлийн химийн бодис үүнээс тусгай зөвшөөрөлтэй 5 нэр төрлийн бодис, тусгай зөвшөөрөл авах 18 нэр төрлийн бодис
7. Баяжуулах фабрикт хагас үйлдвэрлэлийн туршилт хийх, 25 хоног  
Төмөр-цайрын хүдрийг нойтон соронзон аргаар төмрийг баяжуулж, хөвүүлэн баяжуулах аргаар цайрыг ялган 2 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Төлөвлөлтийн дээрх үндсэн нөхцөлүүдэд үндэслэн дүгнэхэд:
  - Төсөл хэрэгжүүлэгч нь “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэрийн баяжуулах фабрикт цайр агуулсан төмрийн хүдэр боловсруулах хагас үйлдвэрлийн туршилт хийх үйл ажиллагааг төлөвлөлтийн дагуу явуулах, химийн бодисын хог хаягдлыг төлөвлөгөөнд тусгасны дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх, нөхөн сэргээлтийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу хийж гүйцэтгэн орон нутагт хүлээлгэн өгөх шаардлагатай.
  - Туршилтад хаягдал багатай, эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн техник технологийг хэрэглэх нь илүү үр дүнг өгнө.

**Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт**

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших “Бор-Өндөр УБҮ-ийн Хими лаборатори” төслийн ТЭЗҮ болон бусад холбогдох бичиг баримтыг нарийвчлан судалж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийг БОНХСайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дараах алхамаар тодорхойлсон. Төслөөс үзүүлэх сөрөг нөлөөллийг БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан үзүүлэлтээр байгаль орчны шинжилгээ хийж үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 9. Байгаль орчны шинжилгээ*



| №                  | Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд                                                                                                                                     | Тийм | Үгүй |
|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|------|
| 1                  | Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт                                                                                                                                  |      | +    |
| 2                  | Газар ашиглалтын өөрчлөлт                                                                                                                                                  |      | +    |
| 3                  | Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх                                                                                                                   | +    |      |
| 4                  | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх                                                                                                                |      | +    |
| 5                  | Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх                                                                                                          |      | +    |
| 6                  | Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх | +    |      |
| 7                  | Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх                           |      | +    |
| 8                  | Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх                                                      | +    |      |
| 9                  | Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх                                              |      | +    |
| Орчны бохирдол     |                                                                                                                                                                            |      |      |
| 10                 | Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгарах эсэх                                                      |      | +    |
| 11                 | Дуу шуугианы нөлөө                                                                                                                                                         |      | +    |
| 12                 | Чичиргээний нөлөө                                                                                                                                                          |      | +    |
| 13                 | Дулааны нөлөө                                                                                                                                                              |      | +    |
| 14                 | Цахилгаан соронзон долгионы нөлөө                                                                                                                                          |      | +    |
| 15                 | Цацрагийн нөлөө                                                                                                                                                            |      | +    |
| 16                 | Гадаргын болон газрын доорх усанд бохирдуулагч бодис нэвчих үед усны бохирдол үүсэх эсэх                                                                                   |      | +    |
| Эрсдэлийн үнэлгээ  |                                                                                                                                                                            |      |      |
| 17                 | Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл                                                                                                                             | +    |      |
| 18                 | Байгаль орчинд үүсэх эрсдэл                                                                                                                                                | +    |      |
| Нийгэм-эдийн засаг |                                                                                                                                                                            |      |      |
| 19                 | Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор нийгэмд тодорхой өөрчлөлт гарах эсэх                                                                                                    | +    |      |
| 20                 | Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх                                                                                                                                     | +    |      |
| 21                 | Бизнесийн таатай орчин бүрэлдэх                                                                                                                                            | +    |      |
| 22                 | Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх                                                                                                                                       | +    |      |
| 23                 | Шинээр ажлын байр бий болох                                                                                                                                                | +    |      |
| 24                 | Орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх                                                                                                                                       | +    |      |
| 25                 | Хөдөлмөр эрхлэлтэд өөрчлөлт гарах                                                                                                                                          |      | +    |
| 26                 | Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг зэрэгт сөргөөр нөлөөлөх                                                                                           |      | +    |
| 27                 | Тухайн орон нутгийн оршин суугчдын дасан зохицсон амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх                                                                                     |      | +    |



|    |                                                                                                                                                                                                 |   |   |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|
| 28 | Хөгжлийн хэтийн төлөвлөгөө, тухайн үед орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, бусад хүчин зүйлс байгаа эсэх |   | + |
| 29 | Байгаль орчны бохирдол, доройтол үүсгэж болзошгүй зам, тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд явагдах эсэх                                                      | + |   |

Дээрх байгаль орчны шинжилгээний үр дүнг үндэслэн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгдөх байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохдоо “Магадлан жагсаах арга”-ыг ашиглав. НҮБХХБ болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлалд заасан магадлан жагсаах аргын хувилбарыг нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлоход ашигласан болно.

**Хүснэгт 20. Нөлөөллийн магадлан жагсаах аргын матриц**

| Үзүүлэлт                                                                         | Технологийн процесс                |                            |                              |                                       |                             |                   | Нийлбэр |
|----------------------------------------------------------------------------------|------------------------------------|----------------------------|------------------------------|---------------------------------------|-----------------------------|-------------------|---------|
|                                                                                  | Химийн бодис, материалыг тээвэрлэх | Химийн бодис ачих, буулгах | Үйлдвэрлэлийн үндсэн процесс | Эцсийн бүтээгдэхүүн, түүний хадгалалт | Аюултай шинжтэй хог хаягдал | Ахуйн хог хаягдал |         |
| Агаарын чанар                                                                    | +                                  | +                          | +                            | +                                     | +                           | +                 | 6       |
| Хөрсөн бүрхэвч                                                                   | +                                  | +                          | 0                            | +                                     | +                           | +                 | 4       |
| Ургамлан нөмрөг                                                                  | +                                  | +                          | 0                            | +                                     | +                           | +                 | 4       |
| Геологийн тогтоц                                                                 | 0                                  | 0                          | 0                            | 0                                     | 0                           | 0                 | 0       |
| Газрын доорх усны нөөц, горим                                                    | 0                                  | 0                          | 0                            | 0                                     | 0                           | 0                 | 0       |
| Газрын доорхи усны чанар                                                         | 0                                  | +                          | 0                            | +                                     | +                           | +                 | 4       |
| Гадаргын усны нөөц, горим                                                        | 0                                  | 0                          | 0                            | 0                                     | 0                           | 0                 | 0       |
| Геоморфологийн хэв шинж                                                          | 0                                  | 0                          | 0                            | 0                                     | 0                           | 0                 | 0       |
| Биологийн олон янз байдал, зүйлийн элбэгшил, тархалт                             | +                                  | 0                          | +                            | 0                                     | +                           | +                 | 4       |
| Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх                                           | 0                                  | 0                          | 0                            | 0                                     | 0                           | 0                 | 0       |
| Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг зэрэгт сөргөөр нөлөөлөх | 0                                  | 0                          | 0                            | 0                                     | 0                           | 0                 | 0       |
| Хүний эрүүл мэнд                                                                 | +                                  | +                          | +                            | +                                     | +                           | +                 | 6       |
| Нийлбэр                                                                          | 5                                  | 5                          | 3                            | 5                                     | 6                           | 6                 |         |

Жич: (+) – нөлөөлөл үзүүлнэ, (0) нөлөөлөл үзүүлэхгүй, (х) хамааралгүй.



Магадлан жагсаах аргын үнэлгээний үр дүнгээс үзэхэд төслийн үйл ажиллагаанаас байгаль, нийгэм-эдийн засгийн бүрдэл хэсгийн хамгийн их нөлөөлөлд өртөгдөх бүрдэл хэсэг нь агаарын чанар, хүний эрүүл мэнд байна. Технологийн бүх процесс нь агаарын хими, физик шинж чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, ачих буулгах, хадгалалтын горим алдагдсан үед агаарт тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт асгарсан тохиолдолд хөрс, ургамлан чанарыг доройтуулахаас гадна хөрсний нэвчилтээр газрын доорхи усыг бохирдуулж болзошгүй юм. Мөн тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед үүсэх дуу чимээ нь агаарын физик шинж чанарт нөлөөлнө.

Төсөл хэрэгжүүлэгчийн онцгой анхаарч ажиллах нэг асуудал бол аюултай хог хаягдал юм. Хог хаягдал үүсэхээс, устгах хүртэлх процессод орчны агаарын чанар, усны чанар, хөрсний чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй тул төслийн аливаа үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг “Хог хаягдлын тухай хууль”-ийн дагуу хадгалж, тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлсэн.

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Тус байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөг Монгол улсын Байгаль хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох журам дүрэмийг үндэслэн боловсруулсан.



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 21

| Бор-Өндөр УБҮ-ийн Хими лаборатори төслийн Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт |                                         |                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                             |                         |
|-----------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|
| Д/д                                                                                                 | Үзүүлэлт                                | Төлөвлөсөн ажил                                                                                                                                                                                                                              | Гүйцэтгэл                                                                                                                                                                   |                         |
| Агаар                                                                                               |                                         |                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                             |                         |
| 1.                                                                                                  | I. Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Химилаборит хадгалж буй 60 орчим төрлийн химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, дохио, үг, аюулын тухай тэмдэглэгээг агуулахын гадна болон дотор харагдахуйц байрлалд тодоор зурж, бичиж байрлуулах. | Химилабораторит хадгалж буй химийн бодисын хор, аюулын шинж чанараас хамааруулан зохих анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг химийн бодис тус бүрээр байршуулсан.<br>Хавсралт №1 | Үйл ажиллагааны зардалд |





“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ

|  |  |                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                           |  |
|--|--|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|  |  | Туршилтад ашиглах, хадгалагдаж буй бодисуудын ууршилтад байнга хяналт тавьж бүртгэлжүүлэх.                                                             | Өдөр тутам хяналт тавьж ажилласан. 2022 онд лабораторийн болон агуулахын өрөөний агааржуулалтын хоолойг сольсон. Агааржуулалт хэвийн байгаа.<br>Зургийг хавсаргав.<br><br>Хавсралт №2                                                                                                                                     |  |
|  |  | Баяжуулах үйлдвэрлэлд ашиглах тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хянаж. Тогтоосон хугацаанд үзлэг хийх.                                            | Сар бүр дараах тоног төхөөрөмжийн техникийн паспорт хөтөлж, бүртгэл тэмдэглэл хөтөлдөг.<br>1. Ротометр КФК-3 ЗОМ<br>2. Шатаах зуух СНОЛ 7/1200<br>3. Татах шүүгээ /Сорох шүүгээ/<br>4. Ус нэрэгч ДЭ-25<br>Хавсралт №3                                                                                                     |  |
|  |  | “Хог хаягдал ачиж тээвэрлэх тухай” гэрээний дагуу тогтмол хугацаанд зөөж тээвэрлэх, зориулалтын, стандартын шаардлага хангасан хог хаягдлын цэгт хаях. | Химилабораторийн дотор талд 60л хэмжээтэй 3 ангилан ялгах сав, гадна талбайд 200 л багтаамж бүхий таг, битүүмжлэлтэй, тэмдэг бүхий 3 ангилан ялгах хогийн сав байрлуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Хуванцар сав</li> <li>• Ашиглалт дууссан принтерийн хор</li> <li>• Бусад хог хаягдал</li> </ul> |  |



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ

|  |  |                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |  |
|--|--|----------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|  |  |                                                                                        | <p>“Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ-тай байгуулсан 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн ВU-2024-04-09 дугаартай “Хог хаягдал ачиж тээвэрлэх тухай” гэрээ байгуулан дахин ашиглах боломжгүй 71,27 тонн хог хаягдлыг хуваарийн дагуу 7 хоногийн Даваа, Лхагва, Баасан гаригуудад сумын хог хаягдлын төвлөрсөн цэгт төвлөрүүлсэн. Гэрээ, хог хаягдлын бүртгэлийг хавсаргав.</p> <p>Хавсралт №4</p> <p>Дахивар хог хаягдлыг ангилан ялгаж 5 кг хуванцар савыг сумын дахивар зохицуулах төвд хүлээлгэн өгсөн.</p> <p>Зургийг хавсаргав.</p> <p>Хавсралт №4</p> |  |
|  |  | Гадаргын ба газрын доорх усны нөөц                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |  |
|  |  | Усны шинжилгээг жилд 2 удаа тогтмол хугацаанд мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториудаар | Төсөлд газрын доорхи ба гадаргын усны нөөц байхгүй бөгөөд ус дамжуулах шугам сүлжээгээр усны нөөцийг хангадаг. Орчны хяналт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |  |



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ

|  |  |                                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                         |
|--|--|----------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|
|  |  | сорилт шинжилгээ хийлгэх.                                                                          | <p>шинжилгээг 2025 оны 05 сарын 26-ны өдрийн ЕСМР-2025-02-19 дугаартай “Орчны хяналт шинжилгээ хийх үйлчилгээний гэрээ”-г байгуулан нийт 2 удаа хийж гүйцэтгэсэн.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Гадаад болон дотоод орчинд тоосны хэмжилт</li> <li>2. Дуу чимээний түвшин үнэлэх</li> <li>3. Хөрсний эрүүл ахуй, хөрсний химийн шинжилгээг</li> </ol> <p>Гэрээ, дүн шинжилгээг хавсаргав.<br/>Хавсралт №5</p> |                         |
|  |  |                                                                                                    | Хөрсөн бүрхэвч                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                         |
|  |  | Ахуйн хэрэглээнээс гарч байгаа хаягдлыг ангилах зориулалтын 4 ангилан ялгах хогийн сав байрлуулах. | <p>Химилабораторийн дотор талд 60л хэмжээтэй, 3 ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав байрлуулсан. “Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ-ын зориулалтын машинаар сумын төвлөрсөн хогийн цэгт 71,27 тонн хог хаягдлыг төвлөрүүлсэн.</p> <p>Зургийг хавсаргав.</p>                                                                                                                                                                     | Үйл ажиллагааны зардалд |



“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ХАРЪЯА БОР-ӨНДӨР УБҮ

|    |                           |                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                     |                                                     |
|----|---------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------|
|    |                           |                                                                                                                                                       | Хавсралт №6                                                                                                                                                                                                                                                         |                                                     |
|    |                           | Химийн бодисын агуулах, хадгалах орчны хяналт аюулгүй байдлыг хангаж, химийн бодисын агуулахад тавигдах стандарт (MNS 6458-2014 14х)- ыг дагаж мөрдөх | ISO/IEC 17025:2017 (MNS ISO/IEC 17025:2018) итгэмжлэлийн гэрчилгээтэй.<br><br>Хавсралт №7                                                                                                                                                                           | Үйл ажиллагааны зардалд                             |
|    |                           | Ургамлан нөмрөг                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                     |                                                     |
